



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 08 сарын 30 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ-ээс**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

ХЭЛЭЛЦСЭН нь:

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг **зөвшилцөх**.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг дэмжив.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРОО ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН “ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН
ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ” ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦСӨН
ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, С.Эрдэнэболд, П.Наранбаяр нар төсөлтэй холбогдуулан ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Г.ТЭМҮҮЛЭН



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН “ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН
ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ” ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өртгөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3-т заасныг баримтлан дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.


Төсөл санаачлагчийн зүгээс Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50 МВт-ын блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48 МВт-ын блок станцыг буулгаж, суурин дээр нь 250 МВт-ын блок станц шинээр барих төслийн зураг төсөл боловсруулах, инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар “ДЦС-3” ТӨХК, гүйцэтгэгчээр ОХУ-ын талаас санал болгосон “Интер РАО Экспорт” компанийг томилох асуудлыг зохицуулахаар дурдсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, Н.Батсүмбэрэл, Г.Уянгахишиг, М.Мандхай, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, С.Цэнгүүн, Ч.Лодойсамбуу нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өртгөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Р.СЭДДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН “ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦЫН
ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСЛИЙН ҮНДСЭН ЗУРАГ ТӨСӨЛ
БОЛОВСРУУЛАХ ТУХАЙ” ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙГ ЗӨВШИЛЦӨХ
ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу дээрх хэлэлцээрийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар, Р.Батболд, Б.Түвшин, Ц.Даваасүрэн нар асуулт асууж, үг хэлсэн болно.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийн зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Ц.ДАВААСҮРЭН